



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 04 сарын 05-ны
өдрийн 6197 дугаарт бүртгэв.

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 14/01

Улаан-Уул

**Малын тоо толгойн албан
татварын хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 63.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэхь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь;

1. Малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээдийн малын тоо толгойн албан татварын хэмжээг малын төрөл тус бүр дээр дор дурдсанаар тогтоосугай.

Малын төрөл тус бүрт тогтоосон татварын хэмжээ төгрөгөөр				
Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
0	600	0	0	1000

2. Тогтоолын хэрэгжилтийг хангах, олон нийтэд сурталчилж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), Татварын улсын байцаагч (Г.Эрдэнэсан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 08/19 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.


ДАРГА  С. ГОНГОР

Ёсчилсон 2023 оны 03 сарын 23-ны өдөр

Бүртгэлийн дугаар 09

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар өгөгдөл ажилтны гарын үсэг

2023 оны 03 сарын 23 өдөр

ВПА0002 3007963